МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6-дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.НОМИНЧИМЭГ ТАНАА

2026.06.10 № ХЭГ/2031

танай _____-ны №_____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

"Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг эрхлэх асуудлын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаас бэлтгэн ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хавсралт 25 хуудастай.

Монгол Улсын Засгийн газар
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Баттөмөр Энхбаяр
2026.06.10 18:12

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр Б.Ширэндэвийн гудамж 8/4
Чингэлтэй дүүрэг Улаанбаатар хот 15160
Утас/Факс 976-51 26-75-33
Цахим шуудан info@mojha.gov.mn
Цахим хуудас www.mojha.gov.mn

2026.05.29 № 1/2860

танай _____-ны № _____ -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

"Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2025 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг асуулга тус бүрээр гарган хүргүүлж байна.

Асуулга 1. Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газар болон яам, агентлагийн түвшинд байгуулсан ажлын хэсэг, баталсан төлөвлөгөө, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийн үр дүнгийн нэгдсэн тайлан мэдээлэл:

Засгийн газрын тогтоол батлуулав.

-Улсын Их Хурлын 2025 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг Засгийн газрын түвшинд зохион байгуулах, тус ажлыг эрчимжүүлэх үүднээс Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаас "Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх зарим арга хэмжээний тухай" 206 дугаар тогтоолыг баталсан.

Тогтоолоор эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуульд нийцээгүй, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, авлига, ашиг сонирхлын зөрчил гарах нөхцөл бүрдүүлсэн, зөвшөөрлийн шинжтэй зохицуулалт агуулсан болон холбогдох хууль тогтоомж шинэчлэн батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл хүчингүй болсонтой холбогдуулан дагаж мөрдөхгүй болсон захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгож, хууль тогтоомжид нийцүүлэх, мөн захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг хуулиар зохицуулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тодорхой арга хэмжээ авахыг бүх Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосон.

Түүнчлэн тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг 2026 оны төсвийн багцаас санхүүжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрт хамруулахыг даалгасан.

Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдаас мэргэжил арга зүйгээр хангах үүднээс тогтоолд дурдсан дүн шинжилгээг хийхэд баримтлах Удирдамжийг баталж, мөн захиргааны хэм

хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрийг салбар бүрээр ангилан гаргаж холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтанд тус тус хүргүүлж, удирдамжийн дагуу дүн шинжилгээг хийж, холбогдох хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, үр дүн, тайланг тус яаманд ирүүлэх талаар зөвлөмж бүхий хугацаатай албан бичгийг удаа дараа хүргүүлж, дүн шинжилгээ хийгдэж байна.

Ерөнхий сайдын захирамжаар Ажлын хэсэг байгуулав.

-Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 15 дугаар захирамжаар Улсын Их Хурлын 2025 оны 61 дүгээр тогтоол, Засгийн газрын 2025 оны 206 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад дүрэм, журамд дүн шинжилгээ хийж, тэдгээрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27^1 дүгээр зүйлд нийцүүлэх, хүчингүй болгох, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулж, яамдын дэд сайд нарыг гишүүдээр оруулсан.

Ажлын хэсгийг хуралдуулж яам бүрд дэд ажлын хэсэг байгуулах замаар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд болон харьяа агентлаг, байгууллагын баталсан дүрэм, журамд дүн шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх, уг дүн шинжилгээнд үндэслэн хууль тогтоомжтой зөрчилдсөн, хуулиар эрх олгоогүй байхад баталж мөрдүүлсэн, хуулиар зохицуулах ёстой харилцааг журамласан шийдвэрүүдийг хүчингүй болгож тус яаманд ирүүлэх, хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг хуульд тусгах чиглэлээр хуулийн төсөл боловсруулах чиглэлийг өгч, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Энэ хүрээнд нийт 11 яам, агентлаг болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад дэд ажлын хэсэг байгуулан, бусад байгууллагын хувьд дотоод зохион байгуулалтын хүрээнд дүн шинжилгээг хийж, холбогдох тайлан, мэдээллийг ирүүлэх ажиллагаа хийгдэж байна.

Түүнчлэн, зарим яамдын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан дээрх Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 124 дүгээр захирамжийг батлуулаад байна.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай санамж бичиг байгуулав.

-Бизнесийн үйл ажиллагаанд тавигдах зөвшөөрөл, бүртгэлийн ачааллыг хөнгөвчлөх, хүнд суртлыг арилгах, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур иргэн, аж ахуйн нэгжийн эрх, ашиг сонирхлыг хязгаарлах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл боломжийг арилгах, бизнесийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр татвар, гааль, банк, санхүүгийн салбарт бизнесийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, дүрэм, журамд, судалгаа, дүн шинжилгээ хийж, тэдгээрийн бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг үнэлэх ажлыг Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран хэрэгжүүлэхээр Санамж бичгийг байгуулаад байна.

Энэ хүрээнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, татвар, гааль гэсэн 4 салбарын дүрэм, журамд дүн шинжилгээ хийх ажлыг Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан 5 аргачлалыг шинэчлэн

боловсруулж байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан 5 аргачлалыг шинэчлэн боловсруулах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/48 дугаар тушаалаар эдгээр 5 аргачлалыг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг, мөн аргачлал бүрийг боловсруулах чиг үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг тус тус байгуулан 2026 оны 6 дугаар сард багтаан Засгийн газрын тогтоолоор батлуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Ажлын хэсэгт Улсын Их Хурлын Тамгын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Жендэрийн Үндэсний хорооны ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох яамд, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Монголын Хуульчдын Холбоо, "Нээлттэй нийгэм форум" ТББ зэрэг байгууллагуудын төлөөлөл орсон.

Аргачлалын төслийг боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын төлөөллийг оролцуулсан олон нийтийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд 6 сард багтаан Засгийн газраар хэлэлцүүлж, батлуулсны дараа аргачлал бүрээр үндэсний сургагч багшийг бэлтгэх сургалтыг зохион байгуулж, тэдгээрээр дамжуулан холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Авч хэрэгжүүлж буй арга хэмжээний явц

Захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, агентлагийн дарга, бусад зөвлөл, хороо, комисс, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга зэрэг нийт 47 байгууллагын 73 дүрэм, журмыг хууль тогтоомжтой зөрчилдсөн, хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад баталсан, тусгайлан эрх олгосон хуулийн заалт хүчингүй болсон, өөрчлөгдсөн, эрх зүйн ач холбогдлоо алдсан, журмын зохицуулалт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй үндэслэлээр хүчингүй болгож, 3 байгууллагын 4 дүрэм, журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн баталж, 3 байгууллагын 9 дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулаад байна.

Түүнчлэн хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад баталсан 9 байгууллагын 23, хууль тогтоомжтой зөрчилдсөн 3 байгууллагын 5 дүрэм, журмыг хүчингүй болгох, хуулиар эрх олгосны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй 15 байгууллагын 31 дүрэм, журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд нөхөн бүртгүүлэх ажиллагаа хийгдэж байна.

Асуулга 2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актуудад хийсэн нийцлийн судалгааны үр дүн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27^1 дүгээр зүйлийн $27^1.1$, $27^1.2$ дахь хэсэгт нийцэхгүй гэж тогтоогдсон зохицуулалтын жагсаалт, ангилал, дүгнэлт, судалгааны үр дүнд боловсруулсан хуулийн төсөл, шинэчлэн боловсруулсан болон хүчингүй болгохоор шийдвэрлэсэн захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээлэл:

Хууль зүй, дотоод хэргийн салбарын тухайд:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 25

хууль (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Дотоодын цэргийн тухай, Өмгөөллийн тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Төрийн бэлгэ тэмдгийн тухай, Цагдаагийн албаны тухай, Шүүх шинжилгээний тухай, Харьяатын тухай, Галт зэвсгийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Нотариатын тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай, Хилийн тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай, Хувийн хамгаалалтын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай, Хууль тогтоомжийн тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль)-иар эрх олгосон 80 гаруй захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг хуулиар зохицуулахаар, 30 эрх олгосон заалтыг хүчингүй болгохоор тус тус хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Бусад захиргааны байгууллагын тухайд:

2026 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 131 захиргааны байгууллагын 2728 шийдвэр бүртгэлтэй байгаа бөгөөд 123 захиргааны байгууллагаас дүн шинжилгээ хийж, холбогдох тайлан, мэдээллийг ирүүлээд байна. Энэ хүрээнд 10 байгууллагаас 23 захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг хуульд тусган, хүчингүй болгох, 14 эрх олгосон заалтыг хүчингүй болгох, 9 эрх олгосон заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар нийт 42 хуулийн төсөл боловсруулах санал ирүүлээд байна. (Жагсаалтыг албан бичгийн 1 дүгээр хавсралтаас үзнэ үү.)

Асуулга 3. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй боловч нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалын жагсаалт, тэдгээрийг хүчингүй болгосон эсэх талаарх мэдээлэл:

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний акт баталсан байгууллагуудад захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрээс гадна хянуулж, бүртгүүлэлгүйгээр нийтээр дагаж мөрдүүлж байгаа дүрэм, журам, бусад хэм хэмжээ тогтоосон шийдвэрт дүн шинжилгээ хийх чиглэлийг хүргүүлсэн.

Энэ хүрээнд ирүүлсэн тайлангаас үзэхэд одоогийн байдлаар хуулиар тусгайлан эрх олгогдоогүй байхад баталж, нийтээр дагаж мөрдүүлж байсан 8 байгууллага 9 дүрэм, журмыг хүчингүй болгож, 9 байгууллага 23 дүрэм, журмыг хүчингүй болгох ажиллагааг хийж байна. (Жагсаалтыг албан бичгийн 2 дугаар хавсралтаас үзнэ үү.)

Асуулга 4. Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй боловч хүчин төгөлдөр хэрэглэж байсан захиргааны хэм хэмжээний актын жагсаалт, тэдгээрийг нөхөн бүртгүүлсэн эсэх талаарх мэдээлэл:

Хуулиар эрх олгосны дагуу баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй дагаж мөрдүүлж байсан 15 байгууллагын 31 дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн нөхөн бүртгүүлэх ажиллагаа хийгдэж байна. (Жагсаалтыг албан бичгийн 2 дугаар хавсралтаас үзнэ үү.)

Асуулга 5. Эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдсан, хууль

тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актын жагсаалт болон тэдгээртэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл:

Хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх зүйн ач холбогдлоо алдсан, тусгайлан эрх олгосон хуулийн заалт хүчингүй болсон, өөрчлөгдсөн, үндэслэлээр нийт 37 байгууллагын 62 дүрэм, журмыг хүчингүй болгож, 3 байгууллагын 4 дүрэм, журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлаж, 3 байгууллагын 9 дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулаад байна. Мөн дээр дурдсан үндэслэлээр 3 байгууллагын 5 дүрэм, журмыг хүчингүй болгох ажиллагаа хийгдэж байна. (Жагсаалтыг албан бичгийн 4 дүгээр хавсралтаас үзнэ үү.)

Түүнчлэн, 2025 оны 07 дугаар сараас 2026 оны 05 дугаар сар хүртэлх хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй болон хянуулж, бүртгүүлэхээр ирүүлсэн нийт 124 дүрэм, журмыг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэх, журмын тодорхой зохицуулалтыг тусгайлан эрх олгосон хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцүүлэх, хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалтыг хүчингүй болгох, тухайн дүрэм, журмыг хэрэгжүүлснээр эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж саналаа тусгуулах эрхийг хангах, эерэг болон сөрөг талуудыг харьцуулан судалж, дүрэм, журмын эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тооцоолох чиглэлээр нөлөөллийн шинжилгээг хийх зэрэг үндэслэлээр зөрчлийг арилгуулахаар дүгнэлт хүргүүлж ажиллаж байна.

Асуулга 6. Захиргааны хэм хэмжээний актуудад хийсэн шалгалтаар хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлсэн гэж тогтоогдсон зохицуулалтын талаарх мэдээлэл болон тэдгээрийг хүчингүй болгосон, өөрчилсөн шийдвэрийн талаарх мэдээлэл:

Авлигатай тэмцэх газрын 2024 оны 01/17288 тоот албан бичгээр ирүүлсэн "журмын зарим зохицуулалт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэй, албан тушаалтанд албаны бүрэн эрхээ урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгох, ашиг хонжоо олох нөхцөлийг бүрдүүлсэн нөхцөл байдал тогтоогдсон" талаарх зөвлөмж, түүнчлэн Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан эрх олгосон заалт хүчингүй болсон үндэслэлээр хүчингүй болгосон 1, Гаалийн ерөнхий газраас журмын зохицуулалт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх, гаалийн хилээр нэвтрүүлэх шат дамжлагыг нэмэгдүүлсэн, ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэх эрсдэлтэй гэж дүгнэсэн үндэслэлээр хүчингүй болгож, эдгээр эрсдэлийг арилган шинэчлэн батлуулсан 2 захиргааны хэм хэмжээний акт байна. (Жагсаалтыг албан бичгийн 5 дугаар хавсралтаас үзнэ үү.)

Хавсралт 20 хуудастай.

Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Сайд
Сайнбуян Амарсайхан
2026.05.29 11:16

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2026 оны 05 дугаар сарын 29-ний
өдрийн А/220 тоот албан бичгийн
1 дүгээр хавсралт

Хүснэгт 1. Захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг хуульд тусган, эрх олгосон заалтыг хүчингүй болгох, эрх олгосон заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахаар ирүүлсэн саналын жагсаалт:

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны үндсэн дээр хүчингүй болгох захиргааны хэм хэмжээний актын мэдээлэл			
д/д	**Боловсруулсан болон боловсруулах санал ирүүлсэн хуулийн төсөл**	**Журмын мэдээлэл**	**Санал боловсруулсан байгууллага**
1.1	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/158 дугаар тушаалаар батлсан "Түсгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны журам"	Шүүх шинжилгээний ерөнхий газар
1.2	Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		Шүүх шинжилгээний ерөнхий газар
1.3	Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/11 дүгээр тушаалаар батлсан "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"	Оюуны өмчийн газар
1.4	Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/17 дугаар тушаалаар батлсан "Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах журам"	Оюуны өмчийн газар
1.5	Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Оюуны өмчийн газрын даргын 2021 оны А/08 дугаар тушаалаар батлсан "Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам"	Оюуны өмчийн газар
1.6	Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Оюуны өмчийн газрын даргын 2022 оны А/137 дугаар тушаалаар батлсан "Хамтын удирдлагын байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ажилтанд сургалт зохион байгуулах журам"	Оюуны өмчийн газар
1.7	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 32 дугаар тогтоолоор батлсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам"	Сонгуулийн ерөнхий хороо
1.8	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 14 дүгээр тогтоолоор батлсан "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"	Сонгуулийн ерөнхий хороо
1.9	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 12 дугаар тогтоолоор батлсан Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт	Сонгуулийн ерөнхий хороо

		тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам	
1.10	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 201 дүгээр тогтоолоор батлсан "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"	Сонгуулийн ерөнхий хороо
1.11	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 202 дугаар тогтоолоор батлсан "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам"	Сонгуулийн ерөнхий хороо
1.12	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/102 дугаар тушаалаар батлсан "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтын журам"	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
1.13	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Уул уурхайн сайдын 2014 оны 202 дугаар тушаалаар батлсан "Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам"	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
1.14	Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл		Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
1.15	Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/405 дугаар тушаалаар батлсан "Малын бүртгэлийн журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.16	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар батлсан "Малын удам зүйн үнэлгээний бүртгэлийн журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.17	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/46/115 дугаар хамтарсан тушаалаар батлсан "Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.18	Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А-295 дугаар тушаалаар батлсан "Улсын шилдэг хоршоог шалгаруулах, шагнах журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.19	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А-254 дүгээр тушаалаар батлсан "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, мэдээлэл цуглуулах, үйлчилгээ үзүүлэх журам"	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.20	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалаар батлсан "Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд

1.21	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/130 дугаар тушаалаар батлсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам"	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
1.22	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 тушаалаар батлсан "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
1.23	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 дугаар хамтарсан тушаалаар батлсан "Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг урчлүүлэх журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.24	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 52 дугаар тушаалаар батлсан "Барьцаа гаргуулах, буцаан олгох, барьцааны хэмжээг тогтоох журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.25	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/08 дугаар тушаалаар батлсан "Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.26	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2016 оны А/284 дүгээр тушаалаар батлсан "Гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.27	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 207 оны А/111 дүгээр тушаалаар батлсан "Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам"	Гадаадын иргэн, харьяатын газар
1.28	Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 29/А/13 дугаар хамтарсан тогтоол, тушаалаар батлсан "Жолоочийн даатгалын баталгааны загвар, түүнийг хэрэглэх журам"	Санхүүгийн зохицуулах хороо
1.29	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо
1.30	Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	-	Санхүүгийн зохицуулах хороо

1.31	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.32	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.33	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.34	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.35	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.36	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.37	Даатгалын тухай хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.38	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.39	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.40	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.41	Менгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		-	Санхүүгийн зохицуулах хороо
1.42	Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 3 заалтыг хүчингүй болгох		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.43	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 3 заалтыг хүчингүй болгох		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.44	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.45	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.46	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 2 заалтыг хүчингүй болгох		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.47	Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

1.48	Таримал ургамлын үр, сортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.49	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 3 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.50	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.51	Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 2 заалтад өөрчлөлт оруулах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.52	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 4 заалтыг хүчингүй болгох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.53	Хөдөө, аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох, 1 заалтад өөрчлөлт оруулах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
1.54	Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн шинэчлэн найруулах төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох	Монголбанк
1.55	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтад өөрчлөлт оруулах	Монголбанк
1.56	Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтад өөрчлөлт оруулах	Татварын ерөнхий газар
1.57	Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Захиргааны хэм хэмжээний акт батлагдаагүй бөгөөд эрх олгосон 1 заалтыг хүчингүй болгох	Татварын ерөнхий газар

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2026 оны 05 дугаар сарын 19-ний
өдрийн А/120 тоот албан бичгийн
2 дугаар хавсралт

Хүснэгт 2. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй боловч нийтээр дагаж мөрдүүлэхээр батлсан дүрэм, журам, тэдгээрийг хүчингүй болгосон талаарх мэдээлэл:

1.Хүчингүй болгосон дүрэм, журам		
д/д	Журмын товч мэдээлэл	Хүчингүй болгосон шийдвэр
1.1	Сангийн сайдын 2021 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам", 2 дугаар хавсралтаар батлсан "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам"	Сангийн сайд 2025 оны А/162 дугаар тушаал
1.2	Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам", хоёрдугаар хавсралтаар батлсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"	Сангийн сайд 2025 оны А/162 дугаар тушаал
1.3	Санхүү, эдийн засгийн сайд (хуучин нэрээр), Эрүүл мэндийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2003 оны 226/193/157 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлсан "Эрүүл мэндийн Үндэсний Тооцоо (ЭМҮТ)-ны эрүүл мэндийн тусламжийн үйл ажиллагааны ангилал", 2 дугаар хавсралтаар батлсан "Тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ангилал", 3 дугаар хавсралтаар батлсан "Санхүүгийн эх үүсвэрийн ангилал"	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд, Үндэсний статистикийн хорооны 2026 оны А/94, А/162, А/56 дугаар хамтарсан тушаал
1.4	Эрүүл мэндийн сайдын 2010 оны 377 дугаар тушаалаар батлсан "Цусны аюулгүй байдлыг хангах талаарх заавар, журам"	Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/125 дугаар тушаал
1.5	Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 02 дугаар тогтоолоор батлсан "Хархорин хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам", "Зар сурталчилгааны байгууламжийн төлбөрийн хэмжээ"	Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04/05 дугаар тогтоол
1.6	Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор батлсан "Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам"	Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 299 дүгээр тогтоол
1.7	Завхан аймаг Түдэвтэй сум Засаг даргын 2018 оны А/66 дугаар захирамжаар батлсан "Суманд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний газрын цагийн хуваарь"	Завхан аймаг Түдэвтэй сум Засаг даргын 2025 оны А/120 дугаар захирамж
1.8	Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Засаг даргын 2015 оны А/19 дүгээр захирамжаар батлсан "Худалдаа, үйлчилгээний газрын цагийн хуваарь"	Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Засаг даргын 2025 оны А/44 дүгээр захирамж
1.9	Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Засаг даргын 2015 оны А/19 дүгээр захирамжаар батлсан "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар"	Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Засаг даргын 2025 оны А/61 дүгээр захирамж
2.Хүчингүй болгохоор ажиллагаа хийгдэж байгаа дүрэм, журам		
д/д	Журмын товч мэдээлэл	Хийгдэж буй ажиллагаа
2.1	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/135 дугаар тушаалаар батлсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох	Хүчингүй болгохоор ажиллагаа хийгдэж байна.

	зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үний дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"	
2.2	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/39 дүгээр тушаалаар батлсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар"	Хүчингүй болгохоор ажиллагаа хийгдэж байна.
2.3	Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны А/21 дүгээр захирамжаар батлсан "Электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг 18 насанд хүрээгүй хүүхдэд худалдан борлуулахыг хориглох тухай"	Хүчингүй болгохоор ажиллагаа хийгдэж байна.
2.4	Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны А/63 дугаар захирамжаар батлсан "Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд 18 насанд хүрээгүй хүүхдээр хурдан морь унуулахыг хориглох тухай"	Хүчингүй болгохоор ажиллагаа хийгдэж байна.
2.5	Баянхонгор аймгийн Баянцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлсан "Төв сууринд амьдарч буй иргэдийн дагаж мөрдөх журам"	Хүчингүй болгох асуудлыг хурлаар оруулах талаар сумын Засаг даргад чиглэл хүргүүлсэн.
2.6	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Нохой, муурны албан татварын хэмжээ"	Хүчингүй болгох асуудлыг хурлаар оруулах талаар сумын Засаг даргад чиглэл хүргүүлсэн.
2.7	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10/02 дугаар тогтоолоор батлсан "Сумын ногоон байгууламжид нэвтэрч хохирол учруулсан малыг хашиж, эзэнд нь хариуцлага тооцох журам"	Хүчингүй болгох асуудлыг хурлаар оруулах талаар сумын Засаг даргад чиглэл хүргүүлсэн.
2.8	Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 06/03 дугаар тогтоолоор батлсан "Дахивар хог хаягдал худалдан авах үнийн тариф"	Хүчингүй болгох асуудлыг хурлаар оруулах талаар сумын Засаг даргад чиглэл хүргүүлсэн.
2.9	Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11/03 дугаар тогтоолоор батлсан "Дорноговь аймгийн "	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хурал 2026 оны 6 дугаар сард болохоор товлосонтой холбогдуулан тус хурлаар оруулж шийдвэрлэхээр хүлээгдэж байна.
2.10	Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолоор батлсан "Хадлангийн газрыг бусдад ашиглуулах асуудлыг төлөвлөх, баталгаажуулах, гэрээ байгуулах, хяналт тавих журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.11	Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолоор батлсан "Хадлангийн газрыг бусдад ашиглуулах асуудлыг төлөвлөх, баталгаажуулах, гэрээ байгуулах, хяналт тавих журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.12	Дорнод аймгийн Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 54 дүгээр тогтоолоор батлсан "Сумын төв, суурин газрын тэжээвэр нохойтой өрхөөс авах албан татвар"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.13	Дорнод аймгийн Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 64 дүгээр тогтоолоор батлсан "Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн"-ийн эд хөрөнгийг хамгаалах журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.14	Дорнод аймгийн Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 84 дүгээр тогтоолоор батлсан "Буйр нуурын аялал жуулчлалын бүсэд зорчих иргэн, ААН, тээврийн хэрэгслээс авах хураамжийн журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх

2.15	Дорнод аймгийн Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 04 дүгээр тогтоолоор батлсан "Аялал жуулчлалын отог" ажиллуулах журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.16	Дорнод аймгийн Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлсан "Мал нядалгааны цэг ажиллуулах журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.17	Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02 дугаар тогтоолоор батлсан "Түгээмэл тархацтай байгалийн ашигт малтмалыг иргэд аж ахуй нэгж, байгууллагуудад өөрийн ахуйн болон аж ахуйн хэрэгцээнд ашигласны төлбөрийн хэмжээ"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.18	Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 06 дугаар тогтоолоор батлсан "Халуун ус болон интернет үйлчилгээнд мөрдөгдөх төлбөрийн хэмжээ"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.19	Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар тогтоолоор батлсан "Чойбалсан сумын аялал жуулчлалын маршрут"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.20	Дорнод аймгийн Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 04 дүгээр тогтоолоор батлсан "Ахуй үйлчилгээний цэг, халуун ус ажиллуулах журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хүчингүй болгох асуудлыг хэлэлцүүлэх
2.21	Дорнод аймгийн Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 22 дугаар тогтоолоор батлсан "Суманд архи согтууруулах ундаа худалдан борлуулах журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 2026 оны 2-р улирлын ээлжит 13 дугаар хуралдаан хуралдаанаар хүчингүй болгох
2.22	Дорнод аймгийн Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлсан "Мал нядалгааны цэгт мал хүлээн авах, мал нядлах, малын цэгийг ажиллуулах журам"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 2026 оны 2-р улирлын ээлжит 13 дугаар хуралдаан хуралдаанаар хүчингүй болгох
2.23	Дорнод аймгийн Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 03 дугаар тогтоолоор батлсан "Соёлын төвөөс иргэд, байгууллагад үзүүлж буй үйлчилгээний төлбөр"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 2026 оны 2-р улирлын ээлжит 13 дугаар хуралдаан хуралдаанаар хүчингүй болгох
2.24	Дорнод аймгийн Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 03 дугаар тогтоолоор батлсан "Бэлчээр ашигласны нөхөн төлбөр ногдуулах"	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 2026 оны 2-р улирлын ээлжит 13 дугаар хуралдаан хуралдаанаар хүчингүй болгох

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2026 оны 05 дугаар сарын 19-ний
өдрийн А/2862 тоот албан бичгийн
3 дугаар хавсралт

Хүснэгт 3. Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй боловч хүчин төгөлдөр хэрэглэж байсан захиргааны хэм хэмжээний актын жагсаалт, тэдгээрийг нөхөн бүртгүүлэх ажиллагааны талаарх мэдээлэл:

Нөхөн бүртгүүлэх ажиллагаа хийгдэж байгаа захиргааны хэм хэмжээний акт		
д/д	Журмын товч мэдээлэл	Хийгдэж буй ажиллагаа
2.1	Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлаын сайдын хамтарсан 2019 оны А/579, А/784 дүгээр тушаалаар батлсан "Уламжлалт эмийн түүхий эд болох элбэг ургамлыг түүж бэлтгэх журам"	Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх ажиллагаа хийгдэж байна.
2.2	Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/481 дүгээр тушаалаар батлсан "Нялх балчир хүүхдийг хооллох заавар"	Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх ажиллагаа хийгдэж байна.
2.3	Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/77 дугаар тушаалаар батлсан "Эхийн сүүний хөөцийн банк айгуулж, ажиллуулах журам"	Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх ажиллагаа хийгдэж байна.
